

## СЭТГЭЛ ЗҮЙН ТУСГААР ТОГТНОЛ ЮУНААС ЭХЭЛДЭГ ВЭ

С.Отгонжаргал

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Түүхийн тэнхим

**Өгүүллийн товч утга:** Уг өгүүлэлдээ эх орноо хайрлах үзэл, тусгаар тогтнолын үнэ цэнийг ухамсарлах сэтгэл зүйн үндэс эх түүхээ үнэн мөнөөр нь мэдсэний үр дүнд бий болдогийг гаргаж тавихыг хичээв. Энэ үүднээс урвагч хэмээн нэрийг зүүсэн Дилав Хутагт маань Монгол орондоо эргэж очих нь бүү хэл Монгол хүнтэй уулзах эрх гүй явсан ч энэ хүн Монголдоо хэзээ эч гомдоогүй тусгаар тогтнолынхоо төлөө эцсийн амьсгал хураатлаа зүтгэсэнээр жишээ болгохыг хичээлээ. Монгол хүний эх оронч үзэл, сэтгэл зүйн тусгаар тогтнол юунаас эхэлдэг юм бол?

**Түлхүүр үг:** Эх түүх, Сэтгэл зүйн тусгаар тогтнол

Монгол улсад, Монголын түүхнээ Эх орончдын өдөр гэсэн эрхэм сайхан нэртэй өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг болсонтой холбогдуулж өгүүлэлээ тэрлэхээр шийдсэнээ юуны түрүүнд тэмдэглэе. Хүн бүр эх оронтой ч хүн бүр эх оронч гэдэг энэ эрхэм нэрийг хүртэж чаддаггүй. Тайлбар толиудыг шүүж үзвэл эх оронч гэж эх орон, ард түмэндээ хайртай бөгөөд эх орон ард түмнийхээ төлөө яахаас ч буцахгүй хүнийг хэлнэ гэжээ. Энэ өндөр шалгуурыг давж байж эх оронч гэдэг нэрийг сая авч болдог байна.

Эх орончдын өдөр гэхээр Монголын түүхнээ нэрээ үлдээсэн баатарлаг үйлстэнгүүд өөрийн эрхгүй сэтгэлд бууж байна. Тухайлбал эх орны сөөм газрыг ч харийнханд бүү өг хэмээсэн монголын хүчирхэг төрийг байгуулж явсан Модун Шанью, Монгол төрийн элчийн аминд хүрсэн хэн боловч өчиг асуулганд орж буруутай бол цээрлэл хүртэх хатуу ялыг дэлхий дахинд хүл ээлгэж, Монгол хүний эрдэнэт амийг өөрийн амь мэт хамгаалж чадсан их эзэн хаан Чингис, Монгол төр хямралд орж хаан ширээний төлөөх цуст тэмцлийн үед өөрийн биеийг Монгол төрийн золиос болгож төрлийг төвшитгөж түмнийг амаржуулж чадсан Мандухай сэцэн хатан, "... миний хүүг алсан ч Монголын мянга мянган үрсийг устгаж үл чадна. Энэ өдрөөс эхлэн Цагаан хэрэмнээс хойш хятад шаахайны мөр бүү гарга гэдгийг миний хойч үед үеийн үед сануулж яв" хэмээн гэрээсэлсэн, тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч Чин ван Ханддорж, Монгол улсын тусгаар тогтнол хэний ч өмнө хэзээ ч сөхрөхгүй гэдгийг тунхаглаж зогсоогоороо амиа алдсан Манлай баатар Дамдинсүрэн, Монгол улсын тусгаар тогтнолд аюул нүүрлэж байсан түүхэн ээдрээтэй үед эх орныхоо төлөө амь биеэ үл хайрлан тэмцсэн С.Данзан, Д.Бодоо, Ө.Дэндэв, Д.Сүхбаатар, А.Данзан, Д.Догсом, Д.Лосол, Д.Чагдаржав нарын зэрэг олон олон эх орончдын ачаар өнөөдөр бид өөрийн гэсэн газар шороотой, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн төрт улстай, харийнханы өмнө бөхөлзөхгүй нуруу тэнэгэр явна. Эдгээр эх орончдын ард Монголын нийт ард түмэн бат бэх ар тал нь болон зогсож байж энэ амжилтанд хүрсэн юм. Нэгэн түүхэн баримтыг дурьдахад дэлхийн II дайны төгсгөл үед буюу 1945 оны 2 дугаар сард болсон Ялтын (Крымын) бага хурал дээр БНМАУ-ын тусгаар тогтносон байдлыг бэхжүүлэх асуудлыг хэлэлцэж ЗХУ, АНУ, Их Британи улс БНМАУ-ын статус квог хүлээн зөвшөөрсөн юм. Харин 1945 оны 8 дугаар сард ЗХУ, Хятадын засгийн газар Москва хотноо хэлэлцээр хийх үед Монголын тусгаар тогтнолыг Хятад улс хүлээн зөвшөөрөх асуудал хөндөгджээ. Энэ хэлэлцээр дээр Хятадын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч "Хэрэв Монголын ард түмэн тусгаар тогтнолоо хадгалж байх гэсэн хүсэл эрмэлзлэлээ бүх нийтийн санал

хураалтаар баталбал БНМАУ-ын тусгаар тогтносон байдлыг одоогийн байгаа хилээр нь зөвшөөрөн хүлээнэ" гэжээ. БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид 1945 оны 9 дүгээр сарын 21-нд БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай бүх нийтийн санал хураалтыг 10 дугаар сарын 20-ны өдөр явуулах шийдвэр гаргаж, улсын бага хурлын тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэнд даргатай санал хураалтын төв комиссыг байгуулсан байна. Тэр даруйдаа орон нутагт санал хураалтын 3000 гаруй комисс байгуулагджээ. 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр санал хураалтанд Монголын бүх иргэд идэвхитэй оролцож, ан хийж явсан анчин хүртэл уулнаас буун ирж тусгаар тогтнолын төлөө саналаа өгөн гарын үсгээ зурж чадахгүй ч эрхий хурууныхаа хээгээр баталгаажуулж байсныг Хятадын засгийн газраас тусгайлан ирсэн хяналтын төлөөлөгчид гайхан харж зогсож байсан тухай түүхнээ тэмдэглэгдэн үлджээ. 1945 оны 11 дүгээр сарын 10-нд БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчид санал хураалтын дүнг ЗХУ, Дундад иргэн улсын засгийн газарт тус тус мэдэгджээ. Монголын ард түмэн төрийнхөө тусгаар тогтнолын төлөө бүх нийтээрээ санал өгсөн дүнтэй танилцаж 1946 оны нэгдүгээр сарын 5-ны өдөр Хятад улс, БНМАУ-ын тусгаар тогтнолыг аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрсөн байдаг.

Сэтгэл зүйн тусгаар тогтнол юунаас эхэлдэг вэ, түүн дотроо Монголчуудын энэ агуу сэтгэл зүйн тусгаар тогтнол хэрхэн бүрэлдэн бий болов оо? Дэлхий дахин, хүн төрөлхтөн улс орны тусгаар тогтнолд үе үеийнхээ шалгуурыг тавьсаар ирсэн. Монгол улс ч тэдгээр шаардлагуудыг биелүүлж явснаараа тусгаар тогтнолын өнө эртний түүхтэй, өнө эртний төрт улсын түүхтэй улс юм. МЭӨ III зуунд төрт улсаа байгуулж, тусгаар тогтносон улс гэдгээ хүлээн зөвшөөрүүлж явсан. Урагшаа Цагаан хэрэм, хойшоо Байгал далай, зүүн тийш Солонгос, баруун хил нь одоогийн Дундад Ази хүртэлх асар уудам нутгийг эзэмшээд хүлээн зөвшөөрөхгүй байсан улс орнуудаар тусгаар тогтнолоо зэвсгийн хүчээр хүлээн зөвшөөрүүлж явсан. Дээд тэнгэрт ганц нар, доод газарт ганц хаан гэсэн бодлого дэлхий нийтэд ноёрхож байсан дундад зууны үед хамгийн хүчирхэг байсан Хорезм улс Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байсан. Чингисийн элчийг үл тоон цаазаар авахад Чингис хаан Хорезмыг цэргийн их хүчээр байлдан дагуулж улмаар дэлхийг морин туурайгаараа тамгалж тусгаар тогтнолоо баталгаажуулж явсан. Харин XX зууны үед тусгаар тогтнолын шалгуурт өөрчлөлт орж тусгаар улсууд үндсэн хуультай байх ёстой, олон улсын бичиглэгдсэн хуулийн дагуу бусад гадаад улс орнуудаар хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой гэдгийн дагуу Монгол улс Үндсэн хуулиа баталж, улмаар дэлхийн олон улсуудаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлж чадсан байна. Ийнхүү үе үеийн шалгуурыг Монгол Улс, Монголчууд давсаар иржээ.

Ийм агуу их түүх, баатарлаг өвөг дээдсийн тэмцлээс Монголчууд бидэнд сэтгэл зүйн тусгаар тогтнолын эх тавигджээ. Ерөөс сэтгэл зүйн тусгаар тогтнол нь Монгол улсын маань түүхтэй салшгүй холбоотой байдаг хийгээд өчигдрийн түүх зөв байж ирээдүй хойч үеийнхэнд эх орноо хайрлах эх оронч сэтгэлгээг төлөвшүүлдэг байна.

1944 онд Америкийн Ерөнхийлөгч Рузвельтийн даалгавраар Дэд Ерөнхийлөгч Уэльс Монгол улс бие даа ж тусгаар оршиж чадах уу үгүй юу гэдгийг өөрийн нүдэ эр харан дүгнэхээр Монгол оронд иржээ. Түүнд төрсөн сэтгэгдлийн талаар хожим нь монголч эрдэмтэн О.Латтимор "Дэд Ерөнхийлөгч Монгол улсын Их Сургуулийг үзээд сэтгэл нь маш их хөдөлж "ямар ч гэсэн үндэсний их сургуультай болжээ. Энэ бол улс үндэстэн сэргэхийн билэг тэмдэг" хэмээн тэмдэглэж их сайхан сэтгэгдэлтэй буцсан" гэж дурсан бичсэн байдаг. Дэд Ерөнхийлөгчийг О.Латтиморын хамт эргэж очиход нь Ерөнхийлөгч Рузвельт хүлээн эвч үүлзэн хэд хэдэн асуулт тавьжээ.

Рузвельт: - Монгол улс тусгаар болох хэмжээнд хүрсэн байна уу гэж асуухад

Латтимор: - Хүрэхээр барах уу, тэр улс чинь өндийсөн байна гэхэд дэргэдээс нь Уэльс яг тийм гэж батлан дэмжжээ.

Рузвельт: - Тэр гадаад Монгол улс чинь Чингисийн уг гал голомт нь мөн үү гэхэд

Латтимор: - Яг Чингисийн төрсөн нутаг газар шороо нь мөн гэж хариулжээ. Рузвельт дахин "Өвөр, Ар хоёр Монголын чинь аль нь Монголын гол хэсэг вэ? Тэр хоёр нэгдэж чадах уу?" гэж асуухад Латтимор авгай дэлгэрэнгүй тайлбарлаж өгчээ.

Ийнхүү Рузвельт 1945 оны 2 дугаар сарын Крымын хэлэлцээрт Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч гарын үсэг зуржээ. Академич Ч.Далай энэ түүхэн үйл явцын талаар "Фрэнклин Рузвельт Монголын талаар зохих мэдлэгтэй болжээ. 1945 оны 2 дугаар сарын 4-нөөс 12-н хүртэл болсон Крымын хэлэлцээрээр Монголын тусгаар тогтнолыг Зөвлөлт Орос, Америк, Англи гурван улсын тэргүүн зөвшөөрч гарын үсэг зурахад Ерөнхийлөгч Рузвельт их үүрэг гүйцэтгэжээ. Эцэст нь дүгнэхэд Фрэнклин Дилано Рузвельт ... их ч мэдлэг боловсролтой, ухаантай, хүн чанартай том зүтгэлтэн байжээ. Монголчууд Рузвельт Ерөнхийлөгчийн ач тусыг мартаж болохгүй билээ. Монголын ард түмний дотор хамгийн өндөр нэр хүнд олсон Ерөнхийлөгч бол Рузвельт мөн" гэжээ.

Бид АНУ-ын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нарыг гүнээ хүндэтгэхийн зэрэгцээ тэдэнд Монголын тухай эерэгээр ойлгуулж чадсан монголч эрдэмтэн О.Латтиморыг мартаж бас болохгүй. О.Латтимор авхай Монгол улсын тусгаар тогтнолын төлөө яагаад ийм их сэтгэл гаргаж хоёр Ерөнхийлөгчид Монголын тухай сэтгэлд нь буутал ухуулах болов оо? Үүнд хариулахын тулд бид энд нэгэн түүхийг сөхөн үзэх хэрэгтэй болж байна. Ар Монголын улс төрийн дурдатгал гэсэн эдүгээ бараг сурвалж маягаар ашиглаж болохоор нэгэн бяцхан ном 1991 онд Улаанбаатар хотноо хэвлэгдсэн билээ. Өмнөх үгийг тэрлэсэн Б.Буянцог "Ороо бусгаа цагийн догшин хуй салхинд дайруулж эх нутаг юугаа арга буюу эгээрэн гарсан тэр хүний тухай бид саяхан болтол ярьдаггүй, дурсахыг хүссэн нэгэн байлаа ч зориглож өөрөөсөө гадагш нь гаргаж чаддаггүй байсан нь түүхийн үнэн билээ" гэж бичсэн байдаг.

Энэ хүн хэн бэ? Яагаад энэ хүний тухай дурсах боломжгүй болов? 1882 оны 10 сарын 8-нд Завхан аймгийн Түдэвтэй сумын нутагт нэгэн хүү мэндэлсэн нь удаж төдөлгүй Дилав хувилгааны тав дахь дүр хэмээн тодорч эцэг эхийн хамт Нарованчин хийдэд залагдан очжээ. Тэрээр 5 настайдаа банди сахил, 7 настайдаа равжун сахил, 21 настайдаа гэцэл сахилыг авсан байна. Түүнд эцэг эхээс нь өгсөн нэр нь Жамсранжав хэдий ч Монголын түүхнээ Дилав хутагт хэмээн тэмдэглэгдсээр иржээ. 1911 онд Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөхөд Дилав хутагт идэвхтэй оролцож Хатанбаатарын цэрэгт цэргийн ламаар өөрийн хүсэлтээр ажилласан байна. Ийнхүү цэргийн ламаар ажиллах хугацаандаа цэрэг эрсийн сэтгэлийг номын ид шид, мэрэг төлгөөрөө ихэд татаж, хүндлэгдэж байсан тухай эдүгээ домог мэт яриа, олон ном шаштирт тэмдэглэгдэн үлджээ. Монголын тусгаар тогтнолд аюул занал бодитой нүүрлээд байсан 1920-иод оны үед Монгол оронд анхны нууц бүлгэмүүд үүсэж улмаар МАН гэсэн хувьсгалт байгууллага байгуулагдав. Энэхүү хувьсгалт байгууллагыг Монголын сэхээрэлт хэсэг болох Бодоо, Данзан, Сүхбаатар, Догсом, Дэндэв, Лосол зэрэг олон олон хувьсгалчид эх орон, тусгаар тогтнолынхоо төлөө байгуулсан юм. Энэ үед Дилав хутагт Монголын ард түмний нэгэн адил Монгол улсынхаа тусгаар тогтнолын төлөө сэтгэл зовж Монгол улсаа аврах арга замыг хайж ядахдаа Чагдаржав, Бодоо,

Догсом нартай танилцаж тэдний зорьж буй үйл хэргийг чин сэтгэлээсээ дэмжиж Орос улсаас гуйх тусламжийн бичигт Богд хааны тамгыг даруулах арга эвийг олоход хувь нэмрээ оруулсан байдаг. Мөн Богд хааны засгийн газар холын Америк улсаас тусламжийг хүсэж нугалбар бичгээ илгээхэд Дилав хутагт гар бие оролцон зүтгэжээ. Энэхүү зүтгэлийг нь сая хүртэл буруугаар үнэлж дүгнэсээр ирсэн юм. Энэ үеийн түүхэн нөхцөл байдлыг авч үзвэл Монгол орон эхлээд Хятадын, дараа нь цагаантны түрэмгийлэлд тусгаар тогтнолоо алдах аюул нүүрлэж Монголын ард түмэн, Богд хаан ч ялгаагүй харийн түрэмгийлэгчдийг хөөн зайлуулахад хаанаас ч хамаагүй тусламж авахад бэлэн болсон үе байсан юм. ЗОУ-аас тусламж гуйх асуудлыг Богд хаан түр азнаж байхыг зөвлөж байсан боловч Америк, Японоос тусламжийн сураг гаралгүй удсан учир ЗОУ-аас тусламж гуйхаар томилогдсон МАН-ын долоон нөхдөд аравнайлан бурхан бүтээж, аян замын ерөөл тавьж зорьсон үйлсээ бүтээхийг хүсэж байсан нь тусгаар тогтнолын асуудал дээр МАН-ын болон Богд хаант засгийн газар нэгдмэл зорилготой байсныг тодорхой харуулдаг. Гэвч Монгол оронд социализм хүчээр байгуулагдаж байсан үед энэхүү үйл явцыг түүхэн үнэнээс гажуудуулан тайлбарлаж Монголын ард түмэн хар шар феодалуудтай эвлэршгүй зөрчилтэйгээр тэмцэлдэж байсан мэтээр бичиж байснаас Дилав хутагтын эх орноо харийн түрэмгийлэгчдээс аврах гэсэн үйлдэл ч эсрэгээр бичигдсээр иржээ. Монголын ард түмэн 1921 оны хувьсгалд нэгдмэл нэгэн фронт болон орсныг эдүгээ түүхийн шар хуудсууд гэрчилсээр байна. МАН-ын анхны хурал дээр энэхүү байгууллагыг байгуулсан удирдагчдын хэлсэн үг эдүгээ МАХН-ын архивт хадгалагдсаар байгаа юм. Тухайлбал Монгол орноо тэгш журамт, баян хүчирхэг улс болгохын тулд эрдэм боловсролыг эрчимтэй хөгжүүлэх, гадаад олон улстай эрх тэгш харилцах, Монгол улсын иргэн бүр жирийн малчнаас ноёд түшмэд хүртэл тэгш эрхтэй, эрх чөлөөтэй байх ёстой гэсэн утга бүхий үгийг энэхүү хурал дээр нэг биш удаа илэрхийлж байв. 1921 оны хувьсгалын ялалтын дараа шинээр байгуулагдсан засгийн газар нь эвслийн засгийн газрын шинжийг агуулж байв. Таван яамдын сайдаа томилохдоо Дотоод яамны тэргүүн сайдад Да лам Тогоочийн Пунцагдоржийг томилсон, мөн Ардын засгийн Ерөнхий сайдад Жалханц хутагт Дамдинбазар, хичээнгүй сайд Цэрэндорж нар томилогдож байсан нь шинэ засгийн газар Богд хаантай тэрсэлдэх зүйлгүй байсныг давхар илэрхийлж байгаа юм. Энэ байдал гар сунган тусалсан их гүрэнд таалагдсангүй. Ийм ч учраас Монголын хувьсгалын төрмөл шинж чанар аажмаар алдагдаж учирмал шинж чанар давамгайлах болсон үед Монголын нэртэй хутагт хувилгаад битгий хэл эгэл жирийн лам хуврагууд ч их гүрний хүчирхийллийн бодлогод автагдаж эхэлсэн юм. Түүхэн ийм хүнд үе Дилав хутагтыг тойрсонгүй. Түүний хөрөнгийг хурааж, 1930 онд хилс хэрэгт холбон мөрдөж эхэлснээр тэрээр эх нутгаасаа оргон зайлхаар шийджээ. Тэрээр 1931 онд эх орноосоо дүрвэн гарч насан эцэслэх хүртлээ харь оронд суухдаа эх орноо Монгол улсаа тусгаар улс болоход нь хүчин зүтгэж явсан юм. Дилав хутагт Америкад бурхны шашны голомтыг үүсгэн хөгжүүлж Монголынхоо түүх соёлыг судлан сурталчилж байхдаа Оуэн Латтимор авхайтай гүн дотно танилцаж түүнтэй өөрийн болон Монгол улсынхаа зовлон жаргалыг хуваалцаж энэ агуу том эрдэмтэнд Монгол улсаа ойлгуулахад ихээхэн нөлөөлжээ. Оуэн Латтимор Дилав хутагтын эрдэм ухааныг ихэд бишрэн хүндэлдэг байснаа дурсан бичсэнээс үзвэл тэр хоёрын харилцаа ямар хэмжээнд байсан нь тодорхой байгаа юм. Түүнийг харь оронд сууж байхад Монгол оронд улаан хувьсгал гарч Монгол орны тусгаар тогтнол устаж байгаа тухай муу мэдээ байнга хүрэхийн зэрэгцээ монголч эрдэмтэд зохиол бүтээлдээ Монгол улсыг тэсч үлдэх эсэх тал дээр эргэлзэж байгаагаа бичиж сэтгэлийг нь ихэд эмзэглүүлж байв. Америкийн монголч эрдэмтэд Монголыг Зөвлөлтийн

Монгол хэмээн баттай итгэн бодит баримтаар нотлохыг оролдож байхад монголч эрдэмтэн Оуэн Латтимор анх удаа Монгол улсыг тусгаар тогтносон улс гэдгийг батлан бичиж тэдний гайхширлыг төрүүлсэн билээ. Оуэн Латтиморт хэн нөлөөлөв өө? Жижиг буурай Монголыг энэ том эрдэмтэн яагаад өмөөрөх болов оо? Оуэн Латтиморын тухай Р.Рупины бичсэн нэгэн сэтгэгдлийг энд шигтгэе. "Оуэн Латтимор бол санаа бодлоо бараг маргахын аргагүйгээр илэрхийлж чаддаг лут хүн байлаа. Монгол, Шинжаан хоёр бол түүний гаргууд мэддэг нутаг нь юм. Улс төр, цэргийн хэрэг түүний тусгайлан судалдаг асуудал нь байсан юм. Дэлхийн II дайнд Оуэн Латтимор АНУ-ын төрийн департамент болоод Чан-Кай-Шигийн зөвлөхөөр ажиллаж байв. Монголын асуудал дээр БНМАУ нь Зөвлөлтийн ноёрхлын гэрч хэмээн би итгэж байхад **Монгол орныг жинхэнэ ёсоор тусгаар тогтносон улс гэж Латтимор үзэж байлаа.** Үүнээсэ болж эх орноосоо урван тэрсэлсэн этгээд гэгдэж буруутсан юм. Тэрээр Жон Хопкинсын Их сургуулийн академичаасаа хөөгдөж эх орноосоо бүрмөсөн зугтаж Канадад, дараа нь Англид улс төрийн орогногч болсон юм" гэжээ. Оуэн Латтимор олон жилийн судалгааныхаа явцад ийм дүгнэлтэнд хүрсэн нь гайхах зүйл биш юм. Монгол улс эрхшээлт замын дор тусгаар тогтнолоо алхам алхмаар баталгаажуулж, олон улсаар хүлээн зөвшөөрүүлж байсан бодит амжилтыг авьяаслаг улс төрч, дэлхийд нэрд гарсан судлаач маш гярхай олж харжээ. Мөн Монголчуудын өвөрмөц шинж чанарыг харгалзахгүйгээр түүхэн үйл явцад хамаагүй дүгнэлт хийх нь алдаа болохыг урьдчилан сануулах болсон байдаг. Монголын бодлогыг Монголын өөрийнх нь нөхцөлд судлах шаардлагатай. \О.Латтимор, Нүүдэлчид ба хувьсгалчид, УБ. 1994 х.8\ гэж тэрээр үзэж байв. Тиймээ Монголын түүхийг олон жил судалсан түүхчдээс ийм л шийдэл гарч байгааг тэмдэглэх хэрэгтэй. Түүхийн эрхээр харьд, хүний нутгаас эх орноо санахын зовлонг ханатлаа амссан Дилав хутагт маань 1962 онд Монгол улс НҮБ-д гишүүнээр элсэж, тусгаар Монгол улсын маань Алтан соёмбот далбаа Америкийн тэнгэрт дэлхийн олон улсын далбаатай эн зэрэгцэн мандахыг харж сэтгэлдээ уйлж зогссон гэдэг. Өмчтөнгүүдийн эсрэг гадны хүчирхийлэл эрчээ авч байсан аймшигт жилүүдэд Оросынхоор бол хөрөнгөтөн, Монголчуудынхаа дунд хувилгаан хэмээн алдаршсан Дилав хутагт өчиггүйгээр егүүтгэгдэх нь тодорхой байсан юм. Харин аз таарч баригдахынхаа өмнөхөн үнэхээр юм үзэж, төлөг буулгадаг хүн гэдгээ батлах шиг амжиж оргожээ. Түүнийг нутагтаа буцах эрхгүй явж байхад гадны олон эрдэмтэд, энгийн хүмүүс **"Монгол улс тэсэхгүй нь ээ, устаж үгүй болох нь ээ"** гэж зүрхийг нь шархлуулж байсан ч тэрээр зүгээр суусангүй Монголоо тусгаар хэвээр нь үлдээх их үйлсэд далайд дусал нэмэр гэгчээр зүтгэж байлаа. Нью-Йоркийн тэнгэрт Монголын далбаа мандаж, Элчин сайдын яам нээгдэхийг нүдээр үзэх хувь тавилантай байсан Дилав хутагт Жамсранжав өөрийн дотны анд Оуэн Латтимор авхайд **Монгол улс минь тэсч үлдлээ** гэж бахархан бас талархан хэлсэн болов уу. Хүчирхэг явсан Чингисийн Монгол түүхийн эрхээр гурав тасарч жижиг буурай орны тоонд орж хэнд ч үл анзаарагдах болсон хүнд эгзэгтэй үед АНУ-ын Ерөнхийлөгч Монгол улсын тусгаар тогтнолыг нааштай хүлээж авахад чин сэтгэлээсээ зүтгэсэн эрхэм анддаа Дилав хутагт талархлын ямар үг хэлсэн бол. Монгол орондоо эргэж очих нь бүү хэл Монгол хүнтэй уулзах эрхгүй явсан энэ хүн Монголдоо хэзээ ч гомдоогүй юм. Монгол хүний эх оронч үзэл, сэтгэл зүйн тусгаар тогтнол юунаас эхэлдэг юм бол?

Монгол улсад эх орончдын өдрийг жил бүр тэмдэглэх болж байгаа нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ болохын зэрэгцээ аль нэг намын өмчилсөн өдөр бус монгол эх орончдоороо бахархах, тэдний жишээгээр шинэ үеийн эх

орончдыг хүмүүжүүлэх боломжийг нээж байна гэсэн утгыг агуулах нь ихээхэн ач холбогдолтой юм. Энэ өдрийг өргөн цар хүрээтэй сурталчилж, эх оронч хүмүүсийг өнөөгийн шалгуураар буюу ажил үйлс, сурлага хөдөлмөрөөр нь үнэлж үнэхээр тэргүүлж, бодит байдал дээр үлгэр дууриал болж байгаа хэн хүнд амьдралд нь дусал нэмэр болох урамшуулал хайрладаг болвоос шударга хөдөлмөрөөр сайхан амьдарч болох юм байна гэсэн итгэлийг бий болгох эх үндэс болох нь дамжиггүй. Түүгээр ч зогсохгүй эх орныхоо төлөө чин сэтгэлээсээ шударгаар зүтгэдэг хүчнийг бий болгох эхлэл байхыг үгүйсгэх аргагүй юм. Чингэвээс Монгол хүн бүрийн дотор би Монгол хүн гэсэн бахархал бий болж эх орондоо сэтгэл тэнүүн алхах сэтгэл зүйн тусгаар тогтнолыг улмаа лавшруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

**Abstract:** The author tried to demonstrate that the sense of patriotism and the spiritual ground to realize the values of independence is developed as a result of knowing the true and original history of the Motherland. Dilav Khutagt's life was taken as an example to explain it. Although he was allegedly named a betrayer, had no right to come back to his homeland-Mongolia and even to meet his countrymen, he did never felt offended, but till the very end of his life he made every effort to defend his country's independence. Where starts the patriotism and spiritual independence of a Mongolian?